Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх
Хэрэгжүүлэгч агентлаг
Эрүүл Мэндийн Газар

ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ
2024 ОНЫ 10 САР

Чингис хот

Эрүүл Мэндийн Газар Хяналт Шинжилгээ Үнэлгээ Мэдээлэлийн Хэлтэсээс бэлтгэн гаргав

Мэдээ хянасан
ХШҮМ*Х-ийн дарга Д.Наранмичид*

Мэдээ нэгтгэсэн
Мэргэжилтэн *Т.Уганжаргал*

Утас : 70562096
Вэб сайт:mohs.khe.gov.mn

Эх, хүүхдийн эрүүл мэнд
/2024 оны эхний 10 сарын байдлаар/

Төрөлт

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 10 сарын байдлаар нийт 865 эх төрсөн ба өнгөрсөн оны мөн үеэс 234 төрөлтөөр буюу 21,3 хувиар буурсан байна. Төрөлтийн түвшин 1000 хүн амд 10,1 байна.
Аймгийн нэгдсэн эмнэлэгт 80,7% /698/ нь сумдаас ирж төрсөн байна.
Кесар хагалгаагаар төрсөн /235/ 27.2 хувийг эзэлж байна

Хүүхдийн эрүүл мэнд

2024 оны 10 сард Аймгийн хэмжээнд 870 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 237 хүүхдээр буюу 21,4 хувиар буурсан байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 454 буюу 52,5 хувь нь эрэгтэй, 416 буюу 47.5 хувь нь эмэгтэй байна. Амьд төрсөн хүүхдийн 4.8/42/ хувь нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төрсөн байна. Төрөөд 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь 98,8 байна.

Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2024 оны 10 сард нялхасын эндэгдэл 15 тохиолдол бүртгэгдсэн ба 1000 амьд төрөлтөд 17,2 байна. Улсын дундаж 12,0

5 хүртэлх насны эндэгдэл 20 тохиолдол бүртгэгдсэн ба 1000 амьд төрөлтөд 23,0 байгаа нь өмнөх оны мөн үеэс 9,4 промилоор өссөн байна. Улсын дундаж 15,1 промил байна.

Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл: Нярайн тархины эмгэг-4, нярайн амьсгалын гачаалын хам шинж-3, осол гэмтэл-4, төрөлхийг гажиг-2 /төрөлхийн цэврүүт хайрс-1, бүдүүн гэдэс төрөлхийн гажиг-1/, хатгалгаа-1, нярайн гэнэт эндэх хам шинж-1, арьсны идээт халдвар-1, судасны бүлэнтэл-1, гэдэсний түгжрэл-1 тус тус бүртгэгдсэн байна.

Жирэмсний хяналт

Жирэмсэний хяналтанд шинээр 979 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдсан ба 92,8 хувь нь эхний 3 сартайд, 6,4 хувь нь 4-6 сартайд, 7 дээш сартайд 0.7 хувь нь хяналтанд орсон байна. Хяналтанд орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 96.6 хувь нь цусны шинжилгээнд хамрагдсан ба цус багадалттай 12 жирэмсэн бүртгэгдсэн байна.
Шинээр хяналтанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс трихомониаз илрүүлэх шинжилгээнд 766 буюу 78.2 хувь эерэг-4, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 763 буюу 77.9 хувь, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 952 буюу 97,2 хувь, эерэг-2, ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээнд 951 буюу 97,1 хувь тус тус хамрагдсан байна.

<u>Нас баралтын үзүүлэлтүүд</u>

2024 оны эхний 10 сарын байдлаар нийт нас баралтын 319 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 31 тохиолдлоор өссөн байна. 219 буюу 68,6 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Нас баралтын түвшин 10000 хүн амд 4,0 байна.

Нийт нас баралтын 25,1 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс 30,0 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна..

Хорт хавдрын шалтгаант нас баралт нийт нас баралтын /79/ 24,8 хувийг эзэлж байна.

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 74 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 23,2 хувийг эзэлж байна. Амиа хорлосон-19, зам тээврийн осол-14, бусад осол-32 /архины хордлого-10,усанд живэх-8, хөлдөлт-5, цахилгаан гүйдэлд цохиулсан ба галд өртөх-3/ бусдад хорлогдсон-7, үйлдвэрийн осол-2 тус тус бүртгэгдсэн байна. 10000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 8,4 байна.

2024 оны эхний 10 сарын байдлаар артери гипертензийн 18 дээш насанд хамрагдсан эрт илрүүлэг үзлэгт нийт 25500/50,8/ хүн хамрагдаж 57,4 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр онош батлагдсан 272 байна. Чихрийн шижин эрт илрүүлэгт 35 ба түүнээс дээш насанд хамрагдсан 22757/72,0/ хамрагдаж чихрийн шижингээр онош батлагдсан 49 тохиолдол байна.

Хөхний эрт илрүүлэг үзлэгт 12853/68,8/ хүн хамрагдаж, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт 1990/44,4/ хүн хамрагдсан байна.

<u>Амбулатори ,стационарын тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд</u>

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 10 сарын байдлаар эмнэлэгт 17809 хүн хэвтэн эмчлүүлж нийт 136907 ор хоног ашигласан бөгөөд дундаж ор хоног 7,7 байна.

Амбулаторит 2024 оны эхний 10 сарын байдлаар 350699 үзлэг хийгдсэний 23,0 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 58,4 хувийг өвчний учир амбулаторит, 9,7 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, үлдэх 8,9 хувийг гэрийн идэвхитэй болон дуудлагын үзлэг эзэлж байна.

Халдварт бус өвчлөл 77538 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна.

2024 оны 10 сарын байдлаар Осол гэмтлийн өвчлөлийн нийт 1398 тохиолдол бүртгэгдсэнээс /928/66.4 эрэгтэй, /470/33,6 эмэгтэй байна. Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаанд: бүх төрлийн уналт /455/32,5%, зам тээврийн осол /312/22,3%, амьгүй механик хүчин өртөх /282/20,1%, хүчирхийлэл /152/ 10,8% түлэгдэлт /83/ 5,9%, тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2024 оны 10 сарын байдлаар 16901 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч гүйцэтгэснээс 12,5% нь алсын дуудлага эзэлж байгаа нь өмнөх оноос 3,3 хувиар буурсан байна. Осол гэмтлийн 365 дуудлага бүртгэгдсэн байна.

10000 хүн амд ногдох халдварт өвчин
2024 оны эхний 10 сарын байдлаар



Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 10 сарын байдлаар 278 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 34,3 ногдож байна.
Улс аймгийн дундажаас доогуур үзүүлэлттэй байна. /Улсын дундаж 78,3/

Халдварт өвчин бүтэц



Нийт халдварт дотор БЗДХ /103/ 37,1 хувь, салхинцэцэг /101/ 36.3 хувь, сүрьеэ /45/ 16.2 хувь, гар хөл амны өвчин /18/ 6.5 хувь, ковид-/3/ 1.1 хувь тус тус бүртгэгдсэн байна.

БЗДХ-ын 103 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 12.7 байна. БЗДХ-ын дотор тэмбүү /37/, гонококкт халдвар /54/, трихомониз /12/, тохиолдол бүртгэгдэж урьд оноос 14 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.